**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 28 өдөр Дугаар А/94 Улаанбаатар хот

Дүүргийн төрийн албан хаагчдын
сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны
2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/11 дүгээр тогтоолын хавсралтын 3.1.3, 3.1.4 дэх заалт, Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Төрийн албан хаагчийн сургаж хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаанд нь чанар үр дүнтэй зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган 2025 оны 06 дугаар сарын 10, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор холбогдох бодлогын хэлтэст ирүүлж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

1225010242

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн
А/84 дугаар захирамжийн хавсралт

## ДҮҮРГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | ТЕЗ-ийн үр дүн | Хөтөлбөрийн үр дүн | Бодлогын үндэслэл | Үйл ажиллагаа, төсөл арга хэмжээ | Шалгуур | Хэм-жих нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Санхүүжилт (мян.төг) | Хариуцагч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Он | Түвшин | | | |
| ЗГҮАХ-4.2.3.8.Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг төрийн албаны шинэчлэлд нийцүүлж, сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлнэ. | | | | | | | | | | | |
| 1. | Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтад үе хамруулна. | Төрийн албан хаагчийн мэдлэг, чадвар, хандлага зан үйлийн түвшин нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэж ажлын дадлага туршлагатай мэргэшсэн албан хаагчаар бүрдсэн байна. | Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.1.3 дахь заалт , 3.1.4 дэх заалт | 1.Төрийн захиргааны албан хаагчийн 40 цагийн чиглүүлэх сургалтад хамруулах | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | тоо | 2024 | - | - | Улсын болон байгууллагын төсөв | ЗДТГ, ААНБ |
| | | | | 2.Төрийн захиргааны албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамруулах | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | тоо | 2024 | - | - | Улсын болон байгууллагын төсөв | ЗДТГ, ААНБ |
| | | | | 3.Төрийн захиргааны албан хаагчийн мэргэшүүлэх давтан сургалтад хамруулах | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | тоо | 2024 | - | - | Улсын болон байгууллагын төсөв | ЗДТГ, ААНБ |
| | | | | 4.Төрийн захиргааны албан хаагчийн ахлах түшмэл мэргэшүүлэх сургалтад | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | тоо | 2024 | - | | Улсын болон байгууллагын төсөв | ЗДТГ, ААНБ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамруулах | | | | | | | |
| | | | | 5.Тасралтгүй сургалтын хөгжлийг ханган ажлын байранд зохион байгуулах онолын болон дадлагын сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалт | Тоо | 2024 | - | 50 хүн | 10 сая | ЗДТГ Холбогдох газар, хэлтэс албад |
| | | | | 6. Ажил мэргэжлийн чиглэлээр гадаад улс оронд зохион байгуулагдах сургалт, семинар, зөвлөгөөн, туршлага солилцох үйл ажиллагаанд оролцох. | Гадаад улсад туршлага судалсан төрийн албан хаагчийн | Тоо | 2024 | 10 | 50 хүн | 140 сая | ЗДТГ, ААНБ |
| | | | | 7.Мэдлэгээ бусдад түгээх санал санаачлагыг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, үр дүн бүхий шилдэг туршлагыг сурталчлах урамшуулах | Зохион байгуулсан сургалт | Тоо | 2024 | - | 10 хүн | Байгууллагын төсөв | ААНБ |
| | | | | 8.Ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн сул орон тоог нөхөн зорилгоор бакалаврт суралцагчдыг орон нутгийн тэтгэлэгт хамруулж дэмжлэг үзүүлэх | Бакалаврын тэтгэлэгт хамруулсан суралцагчийн | Тоо | 2024 | - | 5 оюутан | 30сая | НХХ Боловсролын хэлтэс ХХҮХ |
| ЗГҮАХ 4.2.3.9.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтлан орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч байгаа иргэд хөдөлмөр эрхлэх, жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, орлого олох, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | |
| 3. | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангаж ажиллана. | | | 9.Ажлын байрны орчин | Зохион байгуулсан | Тоо | 2024 | - | - | Байгууллагын төсөв | ААНБ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжид бодит ахиц дэвшил гарч, тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллан төрийн үйлчилгээний чанар сайжирна<br>Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.1.3 дахь заалт , 3.1.4 дэх заалт | нөхцөлийг сайжруулах | арга хэмжээ | | | | | | |
| | | 10.Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2024 | 4 | 200 албан хаагч | Улсын болон байгууллагын төсөв | Эрүүл мэндийн төв ААНБ |
| | | 11. Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах боломж хувилбарыг судлан, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг туслалцаа үзүүлэх | Төрийн албан хаагчийг Түрээсийн болон хөнгөлттэй нөхцлийн орон сууцанд хамруулах. | Тоо | 2024 | - | 30 албан хаагч | Улсын болон байгууллагын төсөв | Засаг даргын орлогч<br>ТХҮХ<br>Холбогдох газар, хэлтэс албад<br>ААНБ Хувийн хэвшил |
| | | 12.Эмч нарыг тогтвор, суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог хангах бодит хэрэгцээ, шаардлагыг үндэслэн орон нутагт ажилласны нэмэгдлийг сар бүр тооцож олгох | Орон нутагт ажилласны нэмэгдэл олгосон эмч | Тоо | 2024 | - | 6 эмч | 51 сая | Засаг даргын орлогч<br>НХХ<br>Боловсролы хэлтэс<br>Эрүүл мэндийн төв |